



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/19

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах,
сэргээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.4, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын "Өргөө онон" ХХК-ий хүнсний дэлгүүр, "Од хангай трейд" ХХК-ий хүнсний дэлгүүр, Цэнхэрмандал сумын "Наран баац" ХХК-ий хүнсний дэлгүүрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатайгаар сунгасугай.

Хүнсний дэлгүүр:

- | | |
|--------------------|----------------------------|
| 1. Бор-Өндөр сум | "Дагшинбумба" ХХК |
| 2. Баян-Адарга сум | "Цэн-Эрхэт" ХХК |
| 3. Биндэр сум | "Наранхул" ХХК |
| 4. Дархан сум | "Дархан Ушир" ХХК |
| 5. Дархан сум | "Үлэмж Орших" ХХК |
| 6. Дадал сум | "Бурхан Халдун мянгат" ХХК |
| 7. Өмнөдэлгэр сум | "Юмт гэгээ" ХХК |
| 8. Хэрлэн сум | "Өсөх Оршихуй" ХХК |

Зоогийн газар:

- | | |
|------------------|-----------------|
| 9. Бор-Өндөр сум | Дэлгэрнуур" ХХК |
|------------------|-----------------|

Баар:

- | | |
|---------------------|---------------------|
| 10. Биндэр сум | "Баргажин байд" ХХК |
| 11. Биндэр сум | "Наранхул" ХХК |
| 12. Жаргалтхаан сум | "Оюухан мөрөн" ХХК |
| 13. Жаргалтхаан сум | "Шинэ асга" ХХК |
| 14. Дархан сум | "Дархан Ушир" ХХК |
| 15. Хэрлэн сум | "Оч манлай" ХХК |

2//.

3. Баян-Адарга сумын "Өгөөмөр онон" ХХК-ий хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн комисс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА